

# “БӨХӨГ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 03-р сарын 17-ны өдөр

№03

Улаанбаатар хот

## Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсгийг үндэслэн “Бөхөг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. “Бөхөг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 10<sup>00</sup> цагт Хан-Уул дүүргийн 13-р хороонд орших “Бөхөг” ХК-ийн байрны хурлын танхимд хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараахь асуудлуудыг хэлэлцүүлсүгэй.

А. Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах,

Б. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон бизнес төлөвлөгөөг батлах,

В. Их хэмжээний хэлцэл хийх, хувьцаа нэмж гаргах асуудлыг шийдвэрлэж ТУЗ-д эрх олгох эсэх,

Г. ТУЗ-ийн ногдол ашиг тараах эсэх талаар гаргасан тогтоолыг хэлэлцэж батлах,

Д. ТУЗ-ийн дарга Б.Даваасүрэнг үүрэгт ажлаас чөлөөлөх, шинээр ТУЗ-ийн даргыг томилох,

3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөр, саналын хуудсаар өгөх сүүлчийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөр тус тус тасалбар болгон тогтоосугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэрийг шийдвэр гарснаас хойш 3 хоногийн дотор Санхүүгийн Зохицуулах Хороо, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д хүргүүлэх, хурлын зарыг өдөр тутмын 2-оос доошгүй сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг телевиз болон Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсаар дамжуулан холбогдох журмын дагуу зарлуулж, хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг Гүйцэтгэх захирал /Ц.Ганцэцэг/-д даалгасугай.

5. Хувьцаа эзэмшигчдийн хуралтай холбоотой хувьцаа эзэмшигчдэд танилцуулах баримт бичгийн жагсаалтыг хавсралт №01, санал авах хуудсыг хавсралт №02, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга, тооллогын комиссын дарга, гишүүдийн бүрэлдэхүүнийг хавсралт №03-т зааснаар баталсугай.

6. Хувьцаа эзэмшигчдэд компанийн 2024 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайлан болон хурлаар хэлэлцэх бусад баримт бичгийн жагсаалттай танилцах боломжоор хангах, хурлын зарыг өдөр тутмын мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдэгдэхийг Гүйцэтгэх захирал /Ц.Ганцэцэг /-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ДАВААСҮРЭН